



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 05 сарын 19 өдөр

Дугаар А/103

Мандалговь

“Монтех дистрибьюшн” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2019 оны 1 дүгээр сарын 22-ны өдрийн А/17 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу орон нутгийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хэрэгцээнд арматурын байрлал, хамгаалалтын үе тогтоогч тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Монтех дистрибьюшн” ХХК-тай 24,970,000 (хорин дөрвөн сая есөн зуун далан мянга) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хэрэгцээнд арматурын байрлал, хамгаалалтын үе тогтоогч тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Монтех дистрибьюшн” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Ууганболд)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060416